



# ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 279

Мандалговь

## Хөрөнгө данснаас хасах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.1, 5.8.г дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Төв халхын дуулалт жүжгийн театрт хавсралтын дагуу 2'377'258 /хоёр сая гурван зуун далан долоон мянга хоёр зуун тавин найм/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг акталж устгахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө акталж устгах ажлыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл, ОНӨА-ны хяналтан дор зохион байгуулж, байгууллагын данс бүртгэлээс хасахыг Төв халхын дуулалт жүжгийн театрын дарга Д.Доржсүрэнд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА



С.БУДЖАВ

АЙМГИЙН ИТХТ-ийн 2014 оны 19 сарын  
18-нд өдрийн 279-р тогтоолын хавсралт



Акталж устгах хөрөнгийн жагсаалт

| Г/Д | Нэр                   | Тоо ширхэг | Ашиглалтанд орсон огноо | Үнэ       | Хуримтлагдсан эгзгэдэл | Үлдэгдэл өртөг |
|-----|-----------------------|------------|-------------------------|-----------|------------------------|----------------|
| 1   | Хурлын сандал         | 10         | 2001.01.01              | 506'520   | 506'520                | -              |
| 2   | Бюгино долгионы станц | 3          | 2007.09.02              | 213'736   | 213'736                | -              |
| 3   | Компьютер             | 2          | 2011.12.30              | 200'000   | 200'000                | -              |
| 4   | Магнитфон             | 1          | 1996.01.01              | 54'270    | 54'270                 | -              |
| 5   | Өнгөт принтер         | 1          | 2010.12.11              | 592'300   | 592'300                | -              |
| 6   | Принтер               | 1          | 2003.01.01              | 810'432   | 810'432                | -              |
|     | Дүн                   | 10         |                         | 2'377'258 | 2'377'258              | -              |